



**OSHA Academy**  
Occupational Safety & Health Training



**МОНГОЛЫН ХӨДӨЛМӨРИЙН  
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА ЭРҮҮЛ АХУЙН  
МЕНЕЖМЕНТИЙН ХҮРЭЭЛЭН**

*Далхийд өрсөлдөх Монгол компанийн төлөө!*

## **ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ (КУРС-709)**



УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

## АГУУЛГА

|  |    |
|--|----|
| КУРСЫН ТАНИЛЦУУЛГА.....  | 4  |
| МОДУЛЬ 1. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА .....  | 5  |
| Модуль 1.1. Хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) хэрэглэх шаардлага .....                   | 5  |
| Модуль 1.2. XXX-ийн хэрэглээ .....   | 6  |
| Модуль 1.3. XXX-ийн төрөл .....  | 6  |
| Модуль 1.4. XXX-ийг хэзээ, хаана хэрэглэх шаардлагатай вэ?.....                        | 6  |
| Модуль 1.5. XXX-ийн төлбөр .....   | 7  |
| Модуль 1.6. XXX – ийн хийц, дизайн .....   | 7  |
| Модуль 1.7. Нурууны бүс.....   | 8  |
| Модуль 1.8. Ажлын хувцас .....   | 8  |
| Модуль 1.9. Доголдолтой, эвдэрхий XXX.....   | 8  |
| Модуль 1.10. Аюулыг Үнэлэх нь.....   | 8  |
| Модуль 1.11. XXX сонгох – Нэг хамгаалах хувцас хэрэгсэл бүх зүйлд таарна гэж үгүй..... | 9  |
| Модуль 1.12. Аюулыг Хянах .....  | 10 |
| МОДУЛЬ 1. ШАЛГАЛТ.....   | 11 |
| МОДУЛЬ 2. XXX-ИЙН ТАЛААРХ СУРГАЛТ .....  | 13 |
| Модуль 2.1. Танилцуулга .....  | 13 |
| Модуль 2.2. Ямар сэдвээр сургадаг вэ? .....  | 13 |
| Модуль 2.3. Ажлын байран дээрх сургалтын арга.....                                     | 15 |
| Модуль 2.4. Онлайн сургалтын тухайд? .....   | 17 |
| Модуль 2.5. Давтан сургалтыг хэзээ явуулах вэ? .....                                   | 17 |
| Модуль 2.6. Сургалтыг хэн явуулах ёстой вэ?.....                                       | 17 |
| Модуль 2.7. Сургалтыг бичгээр баримтжуулах .....                                       | 17 |
| МОДУЛЬ 2. ШАЛГАЛТ.....   | 19 |
| МОДУЛЬ 3. НҮД БА НҮҮРНИЙ ХАМГААЛАЛТ .....  | 20 |
| Модуль 3.1. Ажлын байранд нүдний гэмтэл гарахад юу нөлөөлдөг вэ? .....                 | 20 |
| Модуль 3.2. Нүдийг юу гэмтээдэг вэ?.....   | 20 |
| Модуль 3.3. Осол голчлон хаана гардаг вэ? .....  | 20 |
| Модуль 3.4. Нүдний гэмтлээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? .....                       | 21 |
| Модуль 3.5. Нүдний/нүүрний хамгаалалт ба хэрэглээ .....                                | 21 |
| Модуль 3.6. Стандартад анхаарал хандуулья. . .....                                     | 23 |
| Тоос .....   | 24 |
| Хараазүйн цацраг .....   | 24 |
| Хараазүйн цацраг .....   | 24 |
| Хараазүйн цацраг .....   | 24 |
| Хараа муудах .....   | 24 |
| МОДУЛЬ 3. ШАЛГАЛТ.....   | 26 |

|   |    |
|---|----|
| МОДУЛЬ 4. АМЬСГАЛЫН ЭРХТНИЙГ ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ .....                                   | 27 |
| Модуль 4.1. Эн тэргүүнд тавигдах зүйл – Инженерингийн аргаар шийдэх .....               | 27 |
| Модуль 4.2. Амьсгалын эрхтнийг хамгаалах хөтөлбөрт тавигдах шаардлага .....             | 28 |
| Модуль 4.3. Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгслийг шалгах.....                           | 28 |
| Модуль 4.4. Сургалт .....   | 29 |
| Модуль 4.5. Амьсгалын эрхтнийг хамгаалах хэрэгслийг сонгох нь .....                     | 29 |
| Модуль 4.6. Амьсгалын эрхтнийг хамгаалах хэрэгслийг хэрэглэх нь.....                    | 31 |
| Модуль 4.7. Амьсгалын эрхтнийг хамгаалах хэрэгслийг хадгалах.....                       | 31 |
| Модуль 4.8. Онцгой Байдлын Журам. ....  | 33 |
| Модуль 4.9. Эрүүл мэндийн үнэлгээ, үзлэг .....  | 34 |
| Модуль 4.10. Шүүлтүүр, бортого, канистрийг ялгах нь .....                               | 35 |
| Модуль 4.11. Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгслийг хаана ашиглах шаардлагагүй вэ? ..... | 35 |
| МОДУЛЬ 4. ШАЛГАЛТ.....  | 36 |
| МОДУЛЬ 5. ТОЛГОЙ, ГАР БА ХӨЛИЙН ХАМГААЛАЛТ.....   | 37 |
| Модуль 5.1.Толгойн Хамгаалалт .....   | 37 |
| Модуль 5.2. Гарын Хамгаалалт .....  | 40 |
| Цэвэр резиний хольц.....  | 43 |
| Модуль 5.3. Хөлийн хамгаалалт .....   | 45 |
| МОДУЛЬ 5. ШАЛГАЛТ.....  | 47 |
| МОДУЛЬ 6: ЦАХИЛГААНЫ ХАМГААЛАЛТЫН ХЭРЭГСЭЛ.....   | 48 |
| Модуль 6.1. Цахилгааны хамгаалах хэрэгслийн арчилгаа хэрэглээ .....                     | 48 |
| Модуль 6.2. Туршилт шалгалт.....  | 51 |
| МОДУЛЬ 6. ШАЛГАЛТ.....  | 53 |
| МОДУЛЬ 7. СОНСГОЛЫН ЭРХТЭН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ.....                                      | 54 |
| Модуль 7.1. Чимээ гэдэг нь юу вэ? .....   | 54 |
| Модуль 7.2. Дуу чимээ ба Шуугиан.....   | 54 |
| Модуль 7.3. Ажлын байрны шуугиан аюултай болох үе .....                                 | 55 |
| Модуль 7.4. Шуугианы аюулыг хянах .....   | 57 |
| Хувийн хамгаалах хэрэгсэл.....  | 58 |
| Модуль 7.5. Сонсголыг хамгаалах Хөтөлбөр.....   | 59 |
| Модуль 7.6. Боловсрол ба сургалт .....  | 61 |
| МОДУЛЬ 7 ШАЛГАЛТ.....   | 62 |

## КУРСЫН ТАНИЛЦУУЛГА

### Энэ курс хичээлийн зорилго юу вэ?

Ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах хяналтын аргуудын нэг нь хамгаалах хувцас, хэрэгсэл ашиглуулах. Хамгаалах хувцас хэрэгслийг байгууллагууд Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, Хувийн хамгаалах хэрэгсэл, Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл гэх зэргээр нэрлэдэг. Бид энэхүү хичээлийн материалд Хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) буюу Personal Protective Equipment гэдэг олон улсын нэр томъёог ашиглах болно.

Энэхүү хичээл нь ажил олгогч болон ажилтанд дараах зүйлсийг ойлгоход тус болно.

- XXX-ийн төрлүүдийг ойлгож мэдэх,
- Ажлын байранд “аюулын үнэлгээ” хийхэд шаардлагатай үндсэн мэдлэг авах,
- XXX-ийг нөхцөл байдалтай уялдуулан, тохируулж сонгох чадвартай болох,
- XXX-ийн зөв хэрэглээ ба арчилгааны тухай ямар сургалт шаардлагатай гэдгийг мэдэх.

## МОДУЛЬ 1. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

### Модуль 1.1. Хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) хэрэглэх шаардлага

Аюулыг хянах 5 түвшний аргачлалын эхний 4 шатлал болох аюулыг устгах, орлуулах, инженерингийн болон захиргааны хяналт тогтоох боломжгүй, эсвэл эдгээр аргыг хэрэглэсэн ч тухайн аюулыг бүрэн хянаж чадахааргүй байгаа тохиолдолд ажил олгогч ажилтнууддаа хувийн хамгаалах хэрэгслийг (XXX) хуваарилан өгч хэрэглүүлнэ. Зарим нэгэн ажил олгогч ‘XXX-ийг олгосноор аюулгүй байдлыг хангачихлаа’ гэж буруу ойлгох нь бий. Ажил олгогч ба ажилтан хамтдаа хичээн зүтгэж, аюулгүй эрүүл ажлын орчин бүрдүүлэх нь ажилтны хамгаалагдах баталгаа болдог.

Аюулыг эх үүсвэрээс нь эхлэн хянах нь ажилтнуудыг хамгаалах хамгийн сайн арга. Ажлын байранд ажилтныг бэртээж гэмтээх аюулуудыг удирдах болон боломжит хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулахад инженерингийн буюу захиргааны хяналтыг хэрэглэхийг АНУ-ын ХАБЭА-н Удирдах Газраас зөвлөдөг. XXX-ийг ихэвчлэн олон төрлийн аюулд өртөх боломжийг багасгахын тулд хэрэглэдэг ба XXX нь аюулыг хянах хамгийн наад захын арга гэдгийг мартуузай. Аюулгүй байдлыг хангах хүчин чармайлт багадна гэхээс ихэддэггүй.

#### Ажил олгогчид дараах үүргийг хүлээнэ:

- Ажлын байранд “аюулын үнэлгээ”-г хийж, бие бялдар болон эрүүл мэндэд нөлөөлж болох аюулыг илрүүлж, хянах;
- Ажилтнуудыг тохирох XXX-ээр хангах;
- XXX-ийн хэрэглээ, цэвэрлэгээний талаар сургалт явуулах;
- XXX-ийг засаж сэлбэх, хуучирсан болон эвдэрсэн XXX-г солих;
- Хугацаат хяналт явуулж, XXX-ийн хөтөлбөрийг боловсронгуй болгох, үр нөлөөг үнэлэх, шалгах.

#### Ажилтнууд дараах үүргийг хүлээнэ:

- XXX-г зориулалтын дагуу зөв өмсч хэрэглэх;
- XXX-н талаарх холбогдох сургалтанд суух;
- XXX-г цэвэрлэх, арчлах, засч сэлбэх;
- XXX-г засах, эсвэл солих шаардлага гарвал ахлах буюу удирдах ажилтандаа мэдэгдэх.

XXX-д тавигддаг тусгай шаардлагуудыг Монгол Улсын хууль болон стандартуудад тусгасан байдаг. **“Монгол Улсын ХАБЭА-н тухай хуулийн:**

- 15.1-д: Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.
- 15.2-д: Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна.
- 15.3-д: Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлнэ” гэж заасан байдаг.

## Модуль 1.2. ХХХ-ийн хэрэглээ

ХХХ-д: Гар (бээлий), хөл (гутал), нүд (нүдний шил), чих (чихний бөглөө, чихэвч г.м), толгой болон нүүр (дуулга, шүүгч баг, амны хаалт), бие хамгаалах хэрэгслүүд (бүрэн хувцас, хэт аюултай үед өмсөх өмсгөл, хаалт хязгаарлалт) багтдаг. Ажил олгогч нь ажилтнууд ХХХ-ийг зааврын дагуу зохистой хэрэглэж байгаа эсэх, хэвийн элэгдэлтэй, хямгатай хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавина. Ажилтнууд ХХХ-ийг зааврын дагуу зөв ашиглах ба хамгаалах хүчин чадлыг нь бүрэн дүүрэн гаргаж ашиглахад анхаарна.

ХХХ хэрэглэх шаардлагатай гэж үзэн ажилтнуудад олгосон боловч хэрэглэдэг ажилтнуудын тоо бага үзүүлэлттэй байвал аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хаа нэгэн газраа доголдож байгааг илэрхийлдэг байна.

Дор дурьдсан үндсэн шалтгаанаас үүдэн зөрчил гардаг:

1. Чанартай ХХХ-ээр хангадаггүй.
2. ХХХ-ийг зөв хэрэглэх талаар зааж хяналт тавьдаггүй.
3. ХХХ-ийн хэрэглэх талаар шаардлага тавьж мөрдүүлдэггүй.
4. ХХХ-ийг хэрэглэх тухай тохирох сургалтыг явуулдаггүй.

## Модуль 1.3. ХХХ-ийн төрөл

- Нүүр ба нүдний хамгаалалт
- Толгойн хамгаалалт
- Хөлний хамгаалалт
- Гарын хамгаалалт
- Хамгаалах хувцас
- Хамгаалалтын тосон түрхлэг
- Хормогч /халхавч/
- Хаалт
- Хязгаарлалт

## Модуль 1.4. ХХХ-ийг хэзээ, хаана хэрэглэх шаардлагатай вэ?

ХХХ-г харах, үнэртэх, эсвэл хүрэхэд бэртэл, гэмтэл учруулах дараах нөхцөл байдалд хэрэглэнэ:

- Үйл явцын аюул
- Хүрээлэн буй орчны аюул
- Химийн бодисын аюул
- Цацраг идэвхит бодисын аюул
- Механик үйлчлэл

## Модуль 1.5. ХХХ-ийн төлбөр

Ажлын үеэр хэрэглэгддэг ХХХ-ийг ажил олгогчийн зүгээс ажилтнуудад үнэ төлбөргүй олгох ёстой.

Монгол Улсын ХАБЭА-н тухай хуулийн 15.1-д: “Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй”, 15.2-д: ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах, зардлыг ажил олгогч хариуцна” гэж заасан байдаг. Үүнийг дараах холбоосоор орж үзнэ үү. <https://www.legalinfo.mn/law/details/564?lawid=564>

Ажилтан ХХХ-г хаяж үрэгдүүлсэн, санаатай эвдсэн тохиолдлоос бусад тохиолдолд ажил олгогч нөхөн авч өгөх ёстой. АНУ-д Ажил олгогч нь тухайн ажилданд өөрийнхөө эзэмшдэг ХХХ-ийг гэртээ авч харих ба өөрийн дураар ажлын бус цагт ч хэрэглэж байхыг зөвшөөрсөн тохиолдолд тухайн хэрэгслийн үнийг ажил олгогч төлдөггүй /АНУ-д/.

## Модуль 1.6. ХХХ – ийн хийц, дизайн

Аливаа Хувийн хамгаалах хэрэгсэл тухайн ажлыг гүйцэтгэхэд аюулгүй байдлыг хангасан дизайн, хийцтэй байх шаардлагатай.

### Юу зүүх ёсгүй байдаг вэ?

ХХХ-ийн дүрмийн дагуу, цахилгаанаар ажилладаг машин механизм болон залгуурт хүрэхэд холболт үүсгэж болзошгүй тохиолдолд бөгж, бугуйн цаг, ээмэг, зүүлт ба бусад үнэт эдлэл зүүхийг хориглодог.

### Яагаад ийм дүрэм байдаг вэ?

Энэхүү дүрэм ноцтой бэртлээс хэрхэн хамгаалж болох тухай доорх жишээнээс уншина уу.

#### Жишээ 1. Бөгжнөөс болж хуруугаа гэмтээсэн нь.

Цэргийн байгууллагын нэг ажилтан цэргийн чирэгч машины чиргүүлийн тавцангийн хашлагад гараараа тулан үсэрч буужээ. Энэ үед бөгж нь хашлагад гогдсоноос болж түүнийг газардахад хурууных нь бүх арьс хуу татагдаж, зөвхөн хурууны булчин шөрмөс, хумс үлдсэн байв. Эмнэлгийн түргэн тусламж дуудан, мэс засалд яаралтай оруулсан ба тухайн хүний хэвлийнээс хуруунд арьс шилжүүлэх мэс заслыг хийжээ. Ингэхдээ тухайн хүн 8 удаа мэс засал хийлгэж, 100-аад өдрийг эмнэлэгт өнгөрүүлсний эцэст хуруу нь хагас ажиллагаатай болжээ.

**Жишээ 2.** Эмнэлгийн нэг ажилтан: ‘Сагсан бөмбөг тоглохдоо цагираганд хүрч, довтолж байгаад бөгж нь гогдсоноос болж буухад нь хурууны арьс, яс, үе мөчтэйгөө хуу татагдчихсан хүнийг асарч байсан юм. Нүд хальтирмаар юм билээ’ гэж мэдээлж байжээ.

## Модуль 1.7. Нурууны бүс

Нурууны бүс нь бэртлээс “хамгаалдаггүй” тул хувийн хамгаалах хэрэгсэлд тооцдоггүй.

Нурууны бүс АНУ-ын ХАБЭА-н Удирдах Газар (ХАБЭАУГ)-н нурууны бэртлээс урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээнд ордоггүй. Хэдийгээр ажилтанд хамгаалагдсан мэт сэтгэгдэл төрдөг ч буруу хэрэглэвэл биеийн хөдөлгөөнийг хязгаарлаж, эргономикийн бусад стресс үүсгэх хүчин зүйл болдог. Судалгаагаар нурууны бүсний ач холбогдол нь зөв хэрэглэсэн тохиолдолд ажилтанд хүнд зүйл өргөхөд зөв өргөх техник аргыг “сануулдаг”-т байдаг. Ингэж зөв хэрэглэж чадвал нурууны бэртэл, гэмтэл бага гардаг. Тиймээс АНУ-ын ХАБЭАУГ-аас нурууны бүс болон түүнтэй төстэй хэрэгслийн хэрэглээг хориглодоггүй.

## Модуль 1.8. Ажлын хувцас

Ажлын хувцас нь ажлын гүйцэтгэл болон орчин нөхцөлд тохирсон байх ёстой. Сул ханцуй, зангиа болон бусад нэлмэгэр хувцсыг хөдөлгөөнт машин механизмын дэргэд өмсөх нь аюултай.

Шатамхай шингэн, шүлтлэг болон хортой бодис, цочроох, түлэх үйлчилгээтэй бодист хүрсэн хувцсыг нэн даруй солих нь зүйтэй. Түүнийг сайтар угааж цэвэрлэхээс нааш өмсөж болохгүй.

## Модуль 1.9. Доголдолтой, эвдэрхий ХХХ

Доголдолтой, эвдэрхий хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэж болохгүй нь мэдээжийн хэрэг билээ. ХХХ-г хэрэглэхээс өмнө ажилтныг аюулд өртөхөөс зохих хэмжээнд хамгаалж буй эсэхийг шалгах нь чухал. Гэмтэлтэй ХХХ бол ХХХ биш гэдгийг мартаж болохгүй.

## Модуль 1.10. Аюулыг Үнэлэх нь

Аюулыг үнэлэх гэдэг нь ажлын байранд ажилтны бие махбодь болон эрүүл мэндэд хохирол учруулж болох ямар аюул байгааг илрүүлэх алхам юм. Аюул нь **БОЛОМЖИТ** болон **БОДИТ** аюул гэсэн 2 хэсэгт хуваагдах ба аюулын үнэлгээгээр энэ 2 ангиллыг хоёуланг нь үнэлнэ. Боломжит аюул нь орчноос шалтгаалан эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох аюул юм. Харин бодит аюул нь эрүүл мэндэд шууд хохирол учруулдаг аюул юм.

*Тайлбар: Дэлгэрэнгүйг 700,706-р курс хичээлүүдээс үзнэ үү.*

Аюулыг үнэлэх шалгалтаар ХХХ хэрэглэх шаардлагатай аюул илэрвэл байгууллага:

- Аюул илэрсэн ажлын хэсгийн ажилтан бүрийг зориулалтын ХХХ-ээр хангах;
- Ажлын хэсгийн бүх ажилтанд энэ шийдвэрийг дуулгах;
- Тухайн ажлын хэсгийн ажилтан бүрт ХХХ нь таарч байгаа эсэхийг нягтлах шаардлагатай.



**Модуль 1.11. XXX сонгох – Нэг хамгаалах хувцас хэрэгсэл бүх зүйлд таарна гэж үгүй.**

XXX-ийн бүх хувцас ба хэрэгсэл аюулгүй дизайн, бүтэцтэй байх ёстой бөгөөд цэвэрхэн, найдвартай орчинд хадгалагдах ёстой. Ажил олгогч XXX-ийг сонгохдоо ажилтанд эвтэйхэн байх, таарах талыг бодолцож үзэх хэрэгтэй. XXX-үүд олон хэмжээтэй байдаг тул ажилтанд таарсан хэмжээг сонгохыг хичээх нь зүйтэй. Өөрт нь зөв таарамжтай, эвтэйхэн XXX-ийг ажилтнууд аяндаа хэрэглэж даддаг. Түүнчлэн, хэд хэдэн XXX-ийг нэг дор өмсч, хэрэглэхээр бол зэрэг хэрэглэхэд тохиромжтой байх ёстой. Ажилтанд таарч тохирохгүй XXX өмсгөвөл аюулгүй болж хамгаалагдахын оронд харин ч аюулд өртөх боломжийг нэмэгдүүлнэ. Мөн ажилтнууд таарахгүй, тохиромжгүй XXX-г хэрэглэхээс дургүйцнэ.

АНУ-ын ХАБЭА-н Удирдах Газар, Америкийн Үндэсний Стандартын Институтээс (АҮСИ=ANSI) гаргасан стандарт шаардлагад нийцсэн XXX-ийг хэрэглэхийг шаарддаг. Харин Монгол Улсад дараах стандарт шаардлагад нийцсэн XXX-ийг хэрэглэхийг шаарддаг байгаа. Үүнд:

- Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага MNS /ISO13688:2000 /12х/,
- Сонсголын эрхтэнг хамгаалах нэг бүрийн хэрэгсэл./**чихэвч**/MNS3306:1991 /3х/,
- Толгой хамгаалах хэрэгсэл.Сонсгол хамгаалах хэрэгсэл. **Чихэвч, бөглөө**MNS5388:2004 /4х/,
- Толгой хамгаалах хэрэгсэл.Нүд хамгаалах хэрэгсэл. **Нүдний шил**MNS5389:2004 /4х/,
- Толгой хамгаалах хэрэгсэл. **Дуулга**.MNS5621:2006 /5х/,
- Толгой хамгаалах хэрэгсэл. **Нүүрэвч**.MNS5624:2006 /4х/,
- Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл. **Хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг**MNS5620:2006 /10х/,
- Гарны хамгаалалт.**Бээлий**MNS 5622:2006 /9х/,
- Хөлний хамгаалалт, **Ажлын тусгай гутал**, MNS 5623:2006 /4х/,
- Хамгаалах хашлага.MNS 0012-4-007:1981 /5х/,
- Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага. Хотын стандарт. Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар -2019 он. Энэ стандартад Барилгын хамгаалалтын **хаалт, хашлаганы** талаарх шаардлагууд бий.
- Химийн бодисоос хамгаалах бээлийг сонгохдоо ажиллах бодисын шинж чанар, эсэргүүцэх чадвар болон бээлийний материалын шинж чанарыг харгалзан сонгох ёстой.

Ажил олгогч нь өөрийн эзэмшлийн XXX-ийг хэрэглэх ажилтнууддаа XXX-н талаарх ажил олгогчийн шийдвэрийг мэдээлж, тэдний хэрэглэх XXX нь ажил олгогчийн хийсэн аюулын үнэлгээ, Монгол Улсын ХАБЭА-н тухай хууль болон холбогдох стандартад үндэслэн тогтоосон шалгуурт нийцсэн эсэхийг нягтлан шалгана.

## Модуль 1.12. Аюулыг Хянах

Аюулыг тохирсон аргаар хяналтанд авч, эрсдлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Хяналтын шатлалыг ашигладаг. ANSI Z10-2005, Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн Удирдлагын Тогтолцооны зүгээс ажил олгогч нарт дараах аюулыг хянах шатлалыг хэрэгжүүлэхийг зөвлөдөг.

1. Устгах
2. Орлуулах
3. Инженерингийн хяналт
4. Захиргааны хяналт
5. Хувийн хамгаалах хэрэгсэл

Хяналтыг хэрэгжүүлэх ёстой шат дарааллаар нь жагсаасан бөгөөд эхний шатлалуудыг хэрэгжүүлж үзэлгүйгээр дараагийн шатны арга хэмжээг авах нь үр дүнгүй гэж үздэг. Энэхүү шатлалын дарааллыг баримтлан, үр дүнтэй хэрэгжүүлэхэд эрсдэл ба бэртэл гэмтэл, өвчлөл мэдэгдэхүйц буурч, аюулгүй байдлын тогтолцоо үр дүнгээ үзүүлж эхэлдэг.

*Тайлбар: Хяналтын шатлалын дэлгэрэнгүйг курс 700,706 хичээлүүдээс үзнэ үү.*

## МОДУЛЬ 1. ШАЛГАЛТ

1. Дараах үндсэн шалтгаануудын алинаас нь үүдэж ХХХ-ийн ерөнхий шаардлагыг биелүүлэхгүй зөрчил гардаг вэ?
  - а. Ажил олгогч чанартай ХХХ-ийг олгоогүй
  - б. Ажил олгогч ХХХ-ийн хэрэглэх талаар зөвлөж, хяналт тавиагүй
  - в. Ажил олгогч ХХХ-ийн хэрэглэх талаар зохих сургалт явуулаагүй
  - г. Дээрх бүгд
2. Хувийн хамгаалах хэрэгслийг хэн үнэ төлбөргүй олгох ёстой вэ?
  - а. Ажилтан
  - б. Ажил олгогч
  - в. Даатгалын байгууллага
  - г. Засгийн газар
3. ХХХ-г харах, үнэртэх, эсвэл хүрэхэд бэртэл, гэмтэл учруулах магадлалтай нөхцөлд ашиглаж байгаа бол үүнийг ямар аюулыг хянаж байна гэж үздэг вэ?
  - а. Цацраг туяаны аюул
  - б. Химийн аюул
  - в. Механик үйлчлэл
  - г. Дээрх бүгд
4. Нурууны бүсийг хувийн хамгаалах хэрэгсэлд тооцдог уу?
  - а. Тийм
  - б. Үгүй
5. \_\_\_\_\_ нь ХХХ-ийн хөтөлбөрийн чухал хэсэгт тооцогддог. Яагаад гэвэл энэ нь тухайн ажлын байранд гарсан болон гарч болзошгүй аюулд тохирох ХХХ-ийг сонгоход шаардлагатай мэдээллээр хангадаг.
  - а. Ажиглалтын хөтөлбөр
  - б. Санал хүсэлт авах механизм
  - в. Сургалтын хөтөлбөр
  - г. Аюулын үнэлгээ
6. ХХХ-ийг ихэвчлэн инженерингийн болон захиргааны \_\_\_\_\_ хэрэглэдэг.
  - а. хяналтуудыг орлуулж
  - б. хяналтуудтай хослуулан
  - в. хяналтуудын дараа нь
  - г. хяналтуудын хэрэгцээг багасгахын тулд
7. Аюулын үнэлгээгээр ХХХ шаардагдах аюул илэрсэн болон гарч болзошгүйг олж тогтоовол удирдлагын зүгээс ямар арга хэмжээг авах ёстой вэ?
  - а. Тухайн аюулаас хамгаалахад зориулсан ХХХ-ийг гүйцэтгэгч ажилтан тус бүрт авч өгнө.
  - б. Ажилтан бүрт ХХХ-ийг сонголтын талаарх шийдвэрийг танилцуулна.
  - в. Гүйцэтгэгч ажилтан бүрийг таарч тохирсон ХХХ-ээр хангах
  - г. Дээрх бүгд
8. Нэг ХХХ бүх зүйлд таарна гэж үгүй.
  - а. Үнэн
  - б. Худал

9. Ажлын байрыг судлах хамгийн чухал стратеги бол аюулын үнэлгээ хийх юм.

- а. Үнэн
- б. Худал

10. Ажлын байрны аюулыг хамгийн үр дүнтэйгээр залруулах хяналт нь \_\_\_\_\_ юм.

- а. Захиргааны хяналт
- б. Хувийн хамгаалах хэрэгсэл
- в. Инженерингийн хяналт
- г. Боловсролын хяналт